



1. Зурагт ямар төлөв байдалтай бодисын жижиг хэсгийг дүрслэн үзүүлсэн байна вэ?




- A. шингэн B. хатуу C. хий D. плазма

2. Аль нь хайлах процессыг илэрхийлсэн байна вэ?



- A. 1
B. 2
C. 3
D. 1,3

3. Хийн жижиг хэсгүүд агуулж буй савны ханыг болон өөр хоорондоо мөргөлдснөөр үүсэх хүчийг хийн даралт гэнэ. Баруун талд ялгаатай байдлаар үлээсэн бөмбөлгүүдийн зураг өгөгджээ. Агаарын бөмбөлөгүүд дэх хийн даралт алинд нь хамгийн бага байх вэ?



- A. 1 B. 2 C. 3 D. 4

Аягатай 100 г усанд 5 грамм ёотон хийхэд хэсэг хугацааны дараа ёотон харагдахгүй болж өнгөгүй тунгалаг шингэн үүсдэг бол дараах асуултуудад хариулаарай.

/ 4-5 дугаар асуулт/

4. Дээрх туршилттай холбоотой: “Энэ үед үүссэн өнгөгүй тунгалаг шингэнийг гэх ба ёотон нь, ус нь болно” гэсэн өгүүлбэрт цэгийн оронд тохирох үгийг сонгоорой.

- A. уусгагч, ууссан бодис, уусмал
B. ууссан бодис, уусгагч, уусмал
C. уусмал, ууссан бодис, уусгагч
D. уусмал, уусгагч, ууссан бодис

5. Туршилтын үед ёотонг хурдан уусгахын тулд 1-р сурагч халаах, 2-р сурагч хутгах, 3-р сурагч нунтаглах санал гаргажээ. Аль сурагч оновчтой санал гаргасан бэ?

- A. 1 ба 2 – р сурагч
B. 1 ба 3 – р сурагч
C. 2 ба 3 – р сурагч
D. 1, 2, 3 – р сурагч


6. Гелийн химийн тэмдгийг сонгоорой.

- A. N B. He C. Na D. Ne

7. 3 см × 3 см × 1 см хэмжээтэй зэс хавтангийн массыг тооцоолно уу. Зэсний нягт 8 г/см³ байна.

- A. 24 B. 72 C. 56 D. 48

8. Зурагт ямар хийг хураан авах аргыг илэрхийлсэн байна вэ?



- A. усанд уусдаггүй агаараас хөнгөн
B. усанд уусдаг агаараас хөнгөн
C. усанд уусдаггүй агаараас хүнд
D. усанд уусдаг агаараас хүнд



9. зургийг ажиглаад төгсгөлд нь химийн элемент, нэгдэл, холимгийн аль нь үүссэн болохыг тодорхойлоорой.

A. элемент B. холимог C. нэгдэл D. аль нь ч биш


10. Хэрвээ модны үртэс, төмрийн үртэс 2 холилдсон байвал чи ямар аргаар ялган авах вэ? Тохирох аргыг сонгоно уу.

A. модны үртэс хөнгөн учир шигшиж ялгаж авах боломжтой.
B. төмрийн үртсийг соронзонгоор үйлчилж ялган авна.
C. төмрийн үртэс хүнд учир шигшиж ялгаж авах боломжтой.
D. төмрийн үртэс хөнгөн учир шигшиж ялгаж авах боломжтой.

11. Аль нь химийн үзэгдэл вэ?

A. бензин шатах B. мөс хайлах
C. хөнгөнцагаан хайлах D. лааны тос царцах

12. Дараах урвалын үгэн тэгшитгэлийг гүйцээж, хоосон зайд тохирох бодисын нэрийг сонгоно уу.



A. Магнийн сульфат
B. Магнийн оксид
C. Магнийн хлорид
D. Магнийн гидроксид

13. Метилоранж индикатор нь ямар орчинд улаан өнгөтэй болдог бэ?

A. pH > 7 B. pH < 7 C. pH = 7 D. аль нь ч биш

14. Нэг нь фенолфталеин дусаахад ягаан өнгөтэй болдог нөгөө нь хүрэн байцааны шүүс дусаахад улаан өнгөтэй болдог бол энэ хос бодисыг сонгоно уу.

	Хос бодисууд	
1	саван	угаалгын нунтаг
2	нэрмэл ус	шүдний оо
3	содын уусмал	алимны цуу
4	лимоны шүүс	содын уусмал

15. Химийн бодис хүчилтөрөгчийн орчинд гэрэл, дулаан ялгаруулахгүй явагдах урвалыг гэнэ.

A. шатах урвал B. исэлдэх урвал
C. нэгдэх урвал D. халах урвал

16. Төмөр болон бусад металл тодорхой нөхцөлд элэгдэж, эдэлгээ нь мууддаг. Энэ үзэгдлийг **корроз** гэж нэрлэдэг. Төмрийн зэврэл (корроз) нь айл өрх, улс орны эдийн засагт ихээхэн хохирол учруулдаг. Тэгвэл үүнээс сэргийлэх аргуудаас гурван аргыг сонгоно уу.

Аргууд:


I будгаар будах II давстай усаар шүрших III шингэрүүлсэн хүчлийн уусмалаар арчих
IV тосоор тослох V чийгтэй агаарт байлгаж VI лентээр ороох

A. I, II, IV B. II, IV, VI C. I, IV, VI D. III, IV, VI

17. Зургуудыг ажиглаад аль туршилтаар төмөр хадаас зэврэхийг сонгоно уу.



18. Доорх зурагт далайн түвшнээс дээш өргөгдсөн өдөр болон газар зүйн байршилыг харуулав. Ус буцлах хамгийн бага температурыг сонгоорой.



- А. Алтай хот
В. Улаанбаатар хот
С. Хөх нуурын хотгор
D. Таван богд уулын Хүйтэн оргил

19. Сурагч ямар хөрсөнд ургамал сайн ургахыг судлах туршилтыг хийж дараах үр дүнг гарган авчээ.

Хөрс	Туршилт явуулсан хугацаа	Ургамлын өсөлт /өндөр/
хүчиллэг хөрс	1 сар	7 см
суурилаг хөрс	1 сар	12см
саармаг хөрс	1 сар	10см

Туршилтын хамаарах, үл хамаарах, тогтмол хувьсагчийг зөв тодорхойлсон мөрийг сонгоно уу.

	Хамаарах хувьсагч	Үл хамаарах хувьсагч	Тогтмол хувьсагч
1	Хөрсний орчин	Туршилт явуулсан хугацаа	Ургамлын өндөр
2	Туршилт явуулсан хугацаа	Ургамлын өндөр	Хөрсний орчин
3	Ургамлын өндөр	Хөрсний орчин	Туршилт явуулсан хугацаа
4	Хөрсний орчин	Ургамлын өндөр	Туршилт явуулсан хугацаа

20. Хөрсийг бохирдуулж буй эх үүсвэр болж чадахгүй нь аль нь вэ?

- А. үйлдвэрийн хаягдал усыг ил задгай асгах
В. хог хаягдал, бохир усаа ил задгай хаях
С. дулааны станц, уурын зуух, машины утаа
D. намар модны навч шарлан газар унах